



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2021 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 42

Мандалговь

Орон сууц хувьчлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Орон сууц хувьчлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тус бүр нь 44,6 м.кв талбайтай, 4,728,002 /дөрвөн сая долоон зуун хорин найман мянга хоёр/ төгрөгийн балансын үнэтэй, 3,968,144 /гурван сая есөн зуун жаран найман мянга нэг зуун дөчин дөрөв/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 4 айлын орон сууцны 2 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа иргэдэд хавсралтын дагуу тогтоосон үнээр хувьчилсугай.

Хоёр: Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга бөгөөд Орон сууц хувьчлах товчооны дарга /Ц.Мөнхбат/-д даалгасугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 18- ны
өдрийн 72 дугаар тогтоолын хавсралт

Хувьчлах орон сууцны жагсаалт

№	Эзэмшигчийн нэр	Барилгын байршил	Хөрөнгийн нэр	Байгууллагын нэр	Хэмжээ	Ашиглалтанд орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах үнэ
1	Д.Эрдэнэчулуун	Өндөршил сум	1 тоот орон сууц	ЭМТ	44,6 м2	1987	4728001,98	759857,48	3968144,50	1,000,000
2	Д.Мөнгөнтамир	Өндөршил сум	4 тоот орон сууц	ЭМТ	44,6 м2	1987	4728001,98	759857,48	3968144,50	1,000,000